



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/06

Даланзадгад

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг  
батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.4, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 242 дугаар тушаал, 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн, Бүгд Найрамдах Хятад ард улсад шинэ коронавирусийн халдвар гарч, олон улсад хурдацтай тархаж байгаа нөхцөлд, халдвараас гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Шинэ Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажлын чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийг холбогдох мэдээллээр хангаж, хамтран ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн төвүүдийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга /Б.Мидэрсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

C:\Desktop\2020 on TUSHAAL

161200020

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн  
А/06 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ДЭГДСЭН ТОМУУГИЙН ШИНЭ КОРОНАВИРУСИЙН  
ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ УДИРДЛАГА,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

**Нэг: Удирдлага, зохион байгуулалтын баг:**

- Дарга- М.Цэндсүрэн- Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга

Орлогч дарга- Д.Алтанчимэг- Зоонозын өвчин судлалын төвийн дарга

**Гишүүд:**

- Я.Болдбаатар- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Б.Мидэрсүрэн- Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга
- Ж.Отгонбайгал- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга
- М.Булганчимэг- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Б.Амгалан- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлогын мэргэжилтэн
- З.Ууганбаяр –Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэнд, спорт хариуцсан мэргэжилтэн
- Б.Бямбажав- Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- М.Нямдулам-Эрүүл мэндийн газрын Эдийн засагч
- Л.Лхагвасүрэн- Өрхийн анагаах ухааны холбооны салбар зөвлөлийн дарга
- Р.Тунгалаг – Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын холбооны тэргүүн
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар

Нарийн бичгийн дарга: Б.Нандинболор- Халдварт өвчний бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

**Хоёр: Нийгмийн эрүүл мэндийн баг:**

Дарга- М.Булганчимэг- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Орлогч дарга: Б.Ганцэцэг- Ахмад настан сэтгэцийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

**Гишүүд:**

- Г.Мөнхзүл – Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн
- У.Үүрийнтуяа- Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- М.Цэцэгсүрэн- Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

- Ш.Нэргүймаа – Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан эмч
- Ш.Оюунтуяа- Зоонозын өвчин судлалын төвийн биологич
- Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
- Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд

Нарийн бичгийн дарга: Н.Буян-Ундрах – Өсвөр үе, мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

**Гурав:Эмнэлгийн тусламж үйлчилгээний баг:**

Дарга- Ж.Отгонбайгал- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга

Орлогч дарга: Д.Түвшинзул- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч

Гишүүд:

- Б.Бямбажав- Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Д.Дүүмаам- Эмнэлгийн тусламжийн чанар, сувилахуй хариуцсан мэргэжилтэн
- Б.Мэндбаяр- Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Д.Гантогтох- Дүн бүртгэл мэдээллийн мэргэжилтэн
- Д.Давааноров- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын Зөвлөх эмч
- Д.Чимгээ- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Дотрын Зөвлөх эмч
- Л.Рэнцэнмядаг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвар судлагч
- А.Мөнхтуяа – Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сувилахуйн албаны дарга
- Б.Ууганжавхаа- Зоонозын өвчин судлалын төвийн Тархвар судлаач
- Р.Тунгалаг – Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын холбооны тэргүүн
- Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар

Нарийн бичгийн дарга - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Чанарын албаны дарга

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн  
А/06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ӨВЧЛӨЛӨӨС СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА  
ХЭМЖЭЭ АВАХ БАГУУДЫН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ:**

**1. Удирдлага, зохион байгуулалтын ажлын хэсэг:**

- 1.1 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн зэрэгт үндэслэн шуурхай хариу арга хэмжээ авах, удирдлага зохион байгуулалтаар хангах
- 1.2 Салбар хоорондын байгууллагууд /Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, бусад хүчний байгууллагууд, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд/- тай хамтран ажиллана
- 1.3 Шинэ төрлийн Коронавирусийн өвчлөлөөс сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.
- 1.4 Шаардагдах орны тооцоолол, судалгаа гаргаж, зохион байгуулалт хийх, эмнэлэг дэлгэх бэлтгэлийг хангах
- 1.5 Шаардлагатай үед нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч мэргэжилтэн, резидент эмч болон эмнэлгийн ажилтаны судалгааг гарган сургалтанд хамруулах
- 1.6 Шинэ Коронавирусийн талаар тандалт эрт илрүүлэх оношилгоо эмчилгээ халдварын хяналт сэргийлэлтийн талаар эмч мэргэжилтэнүүдэд сургалт зохион байгуулах
- 1.7 Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэл, тооцоог гаргаж, холбогдох газруудад саналыг хүргүүлж, нөөцийг бүрдүүлэх
- 1.8 Эмч эмнэлгийн ажилчдын хамгаалах хувцасны нөөцийн судалгааг гарган, шаардлагатай төсвийн тооцоог гарган, шийдвэрлүүлэх
- 1.9 Эмч, эмнэлгийн ажилчдын дархлаа дэмжих бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, автомашин, шатахуун, хүний нөөцийн тооцоо судалгаа, төлөвлөлтийг гаргах, нөөцийг хангуулах арга хэмжээ авах
- 1.10 Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан, эмч, эмнэлгийн ажилчид, ард иргэдэд хүргэнэ
- 1.11 Эрүүл мэндийн байгууллагуудаас доорх мэдээллүүдийг авч нэгтгэн, Эрүүл мэндийн яам руу цаг хугацаанд нь явуулна
  - Орны ачаалал: батлагдсан, нэмэлт, дэлгэсэн, эрчимт эмчилгээний орны тоог хүүхэд, насанд хүрэгчдээр;
  - Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт өвчтөний тоо, үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтний тоо, насны бүлгээр;
  - Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт жирэмсэн эмэгтэйн тоо үүнээс амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний тоо, насны бүлгээр;
  - Эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа өвчтөний тоо, насны бүлэг, Олон улсын өвчний 10 дугаар ангиллаар;
  - Яаралтай тусламжийн тасгийн үзлэгийн тоо, үүнээс томуу, томуу төст өвчний үзлэгийн тоо, насны бүлгээр;
  - Түргэн тусламжийн дуудлагын тоо, үүнээс томуу томуу төст өвчний шалтгаант дуудлагын тоо, насны бүлгээр;

- Нас баралтын тоо, үүнээс амьсгалын замын хүнд халдварын шалтгаантай нас баралтын тоо, Олон улсын өвчний 10 дугаар ангиллаар, насны бүлгээр;

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний ажлын хэсэг:**

- 1.12 Коронавирусийн халдварын үеийн оношилгоо, эмчилгээний талаар эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмж өгч арга зүйгээр хангаж, ажиллах
- 1.13 Шинэ Коронавирусийн халдварын үеийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, зохион байгуулах
- 1.14 Эрүүл мэндийн байгууллагуудын тусгаарлах өрөөний бэлэн байдалд хяналт тавьж ажиллах, нэмэлтээр тусгаарлах нөөц өрөөг бэлтгэх чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгөх
- 1.15 Эмнэлгээр үйлчлүүлэгчдийг эрэмбэлэн ангилах, жирэмсний үзлэг, хяналт, бага насны хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх зэрэг нягтралыг бууруулах арга хэмжээг зохион байгуулах
- 1.16 Халдвараас сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг идэвхжүүлэн, эмч, эмнэлгийн ажилтнуудад халдвараас сэргийлэх тархвар судлалын арга хэмжээг авч ажиллах
- 1.17 Алсын дуудлагын үед томилогдсон эмнэл зүйн баг эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэж ажиллах
- 1.18 Эмч мэргэжилтэнүүдийг амьсгал удирдах, эмнэлзүйн удирдамж, сургалт зөвлөмжөөр хангах
- 1.19 Эм, эмнэлгийн хэрэгслийн судалгаа, хангалт, зүй зохистой зарцуулах /нөөцийг үнэлэх, татан авах, хэрэглэх үеийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

**2. Нийгмийн эрүүл мэндийн ажлын хэсэг:**

- 2.1 Шинэ Коронавирусийн зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл, нөхцөл байдалд тухай бүрт эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, хариу арга хэмжээг зохион байгуулна.
- 2.2 Эрүүл мэндийн яамнаас шинэ Коронавирусийн талаар ирүүлж буй мэдээллийг тухай бүрт ард иргэд, эмч эмнэлгийн мэргэжилтэнд үнэн зөв мэдээлж хариу арга хэмжээ авч ажиллах
- 2.3 Амьсгалын замын хүнд халдварын эмнэлэгт суурилсан тандалтыг эрчимжүүлж, хүнд хэлбэрийн тохиолдол бүрээс сорьц авч лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах
- 2.4 Бүх эрүүл мэндийн байгууллагуудад теле хурлыг тухай бүрт хийж, мэдээлэл сургалт сурталчилгааны арга зүй, нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллах
- 2.5 Төр, төрлийн бус байгууллага, аж ахуйн нэгжид чиглэсэн халдварын эрсдэлийг бууруулах, зөвлөмж өгөх, сургалт сурталчилгааг зохион байгуулах, дотоод сургалтыг чиглүүлэх
- 2.6 Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн цахим сүлжээгээр мэдээлэл сурталчилгааг тогтмол хүргэх /и-оффис, пейж, веб хуудас/
- 2.7 Байгууллагууд, иргэдэд зориулсан зөвлөгөө зөвлөмж өгөх шуурхай утас ажиллуулах
- 2.8 Цаг үеийн байдлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулна
- 2.9 Үйлчлүүлэгчдийг амны хаалттай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сурталчлах

- 2.10 Олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, татан авах, түгээх, хуваарилах ажлыг зохион байгуулж, үр дүнд хяналт тавих
- 2.11 Шаардлагатай тохиолдолд байгууллагуудын албан хаагчид, багш, сургууль, цэцэрлэгийн эмч нарыг дайчлан ажиллана. /ерөнхий үгээр/
- 2.12 НЭМ-ийн ноцтой байдал үүсэх үеийн харилцаа холбооны аймгийн багийг ахлаж ажиллах
- 2.13 Эмч эмнэлгийн ажилчдын сэтгэл зүйг дэмжих, ард иргэдийг үнэн зөв мэдээллээр ханган сэтгэл зүйг зөв чиглүүлэх

-oOo-